



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 5/320

Есөнбулаг сум

Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 15 дугаар тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.7 дахь зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн аялал жуулчлалын платформ нэвтрүүлэх ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Насанбат)-т олгосугай.

2.Гэрээний зардалд шаардагдах 19,900,000 (арван есөн сая есөн зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Насанбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж хөрөнгийн зарцуулалтыг тайлагнахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг) -т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

